

ТАНИЛЦУУЛГА

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох протез, ортопедийн жишиг үнэ батлах тухай

2023 оны 08 дугаар сарын 15-ны өдөр

1.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дах хэсэгт “Зайлшгүй шаардлагаар мэргэжлийн /гэмтлийн/ эмнэлгийн байгууллагын дүгнэлтийн дагуу засал эмчилгээ /протез, ортопед/-г гадаад оронд хийлгэхэд түүний нэг удаагийн үнийг Монгол Улсад хийдэг хиймэл эрхтэн, засал эмчилгээ (протез, ортопед)-ний жишиг үнийг баримтлан олгож болно. Монгол Улсад хийдэг хиймэл эрхтэн, засал эмчилгээ (протез, ортопед)-ний жишиг үнийн жагсаалтыг эрүүл мэнд болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална” гэж заасан.

2.Энэхүү хуулийн заалтыг хэрэгжүүлэхээр Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/507, А/112 дугаар тушаалаар жишиг үнийн жагсаалт шинэчлэн баталж, мөрдөж байна. Энэхүү тушаал нь Хууль зүй, дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 5440 дугаарт бүртгэлтэй болно.

3.Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Нийгмийн даатгалын багц хууль болох Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийг тус тус хэлэлцэн баталсан. Дээрх хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

4.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль/шинэчилсэн найруулга/-ийн 14 дүгээр зүйлийн 14.2-т “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох протез, ортопедийн жишиг үнийг хөдөлмөр, нийгмийн хамгааллын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална” гэж заасан.

5.Иймд хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох протез, ортопедийн жишиг үнийг батлах тухай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын болон Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалын төсөл боловсруулав.

6.Одоогийн мөрдөж байгаа тушаалаар нийт 24 төрлийн протез, ортопед 121 00-11 000 000 төгрөгийн зардлыг Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлж байна.

7. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас 2023 оны 7 дугаар сарын байдлаар 3627 иргэн хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авч байгаа бөгөөд үүнээс протез, ортопед хийлгэсэн хүн 4, түүний зардал 5.1 сая төгрөг

/2022 онд протез ортопед хийлгэсэн хүн 9, түүний зардал 7.6 сая төгрөг/ байна. 2023 онд хиймэл эрхтэн, засал эмчилгээний зардалд 120.5 сая төгрөг төсөвлөсөн, 2024 онд 241.1 сая төгрөг төсөвлөсөн байна.

8.Харин шинээр батлах жагсаалтад иргэдээс ирдэг саналын дагуу бионик хиймэл эрхтэн /15 000 000 төгрөг/ гэсэн төрөл нэмсэн. Бионик хиймэл гарын өөрийн өртөг олон улсын түвшинд 10.0-100.0 мянган ам.долларын өртөгтэй боловч манай улсад 5.0 мянган ам.доллараар хийж байна.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох протез, ортопедийн жишиг үнэ батлагдсанаар Нийгмийн даатгалын сангийн төсөвт нэмэлт зардал гарахгүй.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ